

ТА ИНТЕРНЕТ БАНК БОЛОН 319708, 319709  
УТСААР ХОЛБОГДОН ВАЛЮТЫН ХАНШ  
ТОХИРОХ БОЛОМЖТОЙ.

2022.02.10

### Онцлох мэдээ

- ОХУ-ын инфляц 1-р сард 8.73% хүрч 2016 оны эхэн үеэс хойших дээд түвшинг тогтоосон бөгөөд Баасан гарагт болох төв банкны хурлаар дахин бодлогын хүүг өсгөнө гэсэн таамаглалыг бэхжүүллээ. Шинжээчдийн дундах санал асуулгаар бодлогын хүүг 100 суурь нэгжээр өсгөж 9.5% болгоно гэж таамаглаж байна.
- Япон улсын бөөний худалдааны 1-р сарын инфляцийн өсөлт саарсан хэдий ч 11-р сард хүрсэн рекорд дээд түвшинтэй ойролцоо байв. Үүний гол шалтгаан нь түүхий эдийн өндөр үнэ пүүсүүдийг үнээ өсгөхөд хүргэсэн нь байлаа. 12-р сард 8.7% байсан CGPI 1-р сард 8.6% хүрчээ.

### Валютын зах зээл

Хөрөнгө оруулагчдын анхаарал эрсдэл ихтэй хөрөнгүүд рүү шилжсэнээр Австрали болон Шинэ Зеланд долларууд өнөөдөр хэдэн долоо хоногийн дээд цэгт арилжаалагдлаа. Харин ам.доллар өнөө орой зарлагдах АНУ-ын инфляцийн мэдээний өмнө бага хүрээнд арилжаалагдаж байна. Австрали доллар өчигдөр тогтоосон 3 долоо хоногийн дээд цэг 0.7194-с ялимгүй буурч сүүлд 0.717-р арилжаалагдав. Шинэ Зеланд долларын хувьд мөн өчигдөр тогтоосон 2 долоо хоногийн дээд ханш 0.66975 орчимд буюу 0.6685-тай тэнцүү байх зуур эрсдэл багатай иен 115.58 хүрч сүүлийн арилжаануудаа сулхан өндөрлөж байна. Даваа гарагт Европын Холбооны төв банкны ерөнхийлөгч Кристин Лагард өргөтгөсөн чангалах бодлого баримтлах шаардлагагүй гэж мэдэгдсэнээр евро энэ долоо хоногт суларч 1.1416 хүрээд байна.

### Алтны зах зээл

Хөрөнгө оруулагчид АНУ-ын Холбооны Нөөцийн банк мөнгөний бодлогоо ямар хурдтай чангалах талаар сэжүүр өгөх АНУ-ын инфляцийн мэдээг хүлээж байгаа учир Пүрэв гарагт алтны ханш нарийн зайд хэлбэлзэлтэй байна. Өглөөний байдлаар 1 унц алтны ханш 1,833.26 дээр тогтвортой байж Лхагва гарагийн дээд ханштай ойролцоо арилжаалагдаж байна. АНУ-ын алтны фьючерс GCv1 0.1% унаж 1,834.30 ам.доллар боллоо.

### Зэсийн зах зээл

Өнөөдөр хөнгөн цагааны ханш дахин өсөж, Лондонгийн бирж дээр 13 гаруй жилийн дээд түвшинд хүрсэн бол Шанхайн бирж дээр 4 сарын дээд түвшинд ирээд байна. Металл хайлуулагчдын үйлдвэр хаагдаж байгаа нь нөөцийн талаарх айдсыг улам нэмэгдүүлсээр байна. Зэсийн ханшийн хөдөлгөөн биржүүд дээр ялгаатай байлаа. Лондонгийн Металлын Биржийн зэсийн фьючерс бараг өөрчлөгдөөгүй 10,059.50 ам.долларт арилжаалагдаж байгаа бол Шанхайн Фьючерсийн биржийн зэс 3.3% өсөж

Валют	Ханш	24ц өөрч.		
EUR/USD	1.1428	0.03%		
USD/CNY	6.3615	-0.01%		
USD/RUB	74.7125	0.03%		
USD/JPY	115.52	0.00%		
USD/KRW	1196.85	0.05%		
AUD/USD	0.7167	0.08%		
GBP/USD	1.3533	0.00%		
Индекс	Нэгж	24ц өөрч.		
Dow Jones	35768.1	0.86%		
S&P 500	4587.2	1.45%		
NASDAQ	14490.4	2.08%		
FTSE 100	7643.4	1.01%		
Nikkei 225	27598.1	0.07%		
DAX	15482.0	1.57%		
Hang Seng	24709.0	-0.49%		
Метал	Ханш (USD)	24ц өөрч.		
Алт	1834.33	0.05%		
Мөнгө	23.26	-0.24%		
Нүүрс (Чин хуанг дао)	165.84	0.00%		
Зэс (LME)	10059	2.84%		
Төмрийн хүдэр	806.50	1.32%		
Газрын тос (NYME)	89.54	-0.13%		
LIBOR	Хүү	24ц өөрч.		
US 1M LIBOR	0.13%	0.80%		
US 3M LIBOR	0.37%	1.07%		
US 6M LIBOR	0.64%	2.78%		
US 12M LIBOR	1.09%	0.00%		
Бонд	Хүү	24ц өөрч.		
US Treasury 10Y	1.93%	-0.85%		
UK Treasury 10Y	1.43%	-3.96%		
GE Treasury 10Y	0.21%	-20.00%		
JP Treasury 10Y	0.22%	3.81%		
Бонд (Монгол)	Хүү	Дуусах огноо	Өгөөж	24ц өөрч.
Чингис	5.13%	12/5/2022	3.03%	0.07%
Гэрэгэ	5.63%	5/1/2023	3.60%	-0.02%
МУХБ 2023	7.25%	10/23/2023	4.51%	-0.80%
Хуралдай	8.75%	3/9/2024	4.04%	-0.09%
ММС	9.25%	4/15/2024	22.25%	-0.05%
МИК 2024	8.85%	8/2/2024	11.19%	0.00%
Номад	5.13%	4/7/2026	4.75%	-0.08%
Монгол 27	3.50%	7/7/2027	4.97%	-0.07%
Монгол 31	4.45%	7/7/2031	5.40%	-0.06%
Самурай JPY	1.52%	12/25/2023	0.04%	0.00%

Хувьцаа	Ханш	24ц өөрч.
Turquoise Hill Resources	19.99	2.30%
Mongolian Mining Corp	1.95	4.28%
Erdene Resource Dev	0.44	0.00%
Centerra Gold	10.58	-0.84%

Макро эдийн засаг (Монгол)	Огноо	Дүн
Инфляцийн түвшин	2021 (XII)	13.4%
Бодлогын хүү	2022 (I)	6.5%
Банк хоорондын зах зээлийн хүү	2021 (XI)	6.08%
Хадгаламжийн дундаж хүү (төг)	2021 (XII)	7.04%
Хадгаламжийн дундаж хүү (валют)	2021 (XII)	2.04%
Зээлийн дундаж хүү (төг)	2021 (XII)	15.54%
Зээлийн дундаж хүү (валют)	2021 (XII)	9.07%

Ханшийн таамаглал					
Валют	Q1 22	Q2 22	Q3 22	Q4 22	2023
EUR/USD	1.12	1.13	1.15	1.15	1.17
GBP/USD	1.34	1.35	1.36	1.37	1.40
USD/CNH	6.39	6.35	6.40	6.44	6.40
USD/JPY	114	115	115	115	115
USD/RUB	73.0	72.0	73.07	73.0	73.5

Түүхий эд					
Алт	1775	1750	1700	1680	1650
Зэс	9500	9350	9400	9500	9550
Нүүрс	138.13	109.38	93.13	79.38	62.50

Эдийн засгийн голлох тоо мэдээ эх сурвалж: Блүүибэрг

Өмнөх өдрийн үр дүн	Үр дүн	Таам.	Өмнөх
US Wholesale Invt, R MM	2.2%	2.1%	2.1%
GE Trade Balance EUR	6.8B	10.4B	10.9B
IT Industrial Output YY	4.4%	5.0%	6.3%
IT Industrial Output MM	-1.0%	-0.7%	1.9%

Өнөөдөр хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
US Initial Jobless Claims	21:30	230k	238k
US CPI MM	21:30	0.5%	0.5%
JP Corp Goods Price YY	7:50	8.2%	8.5%
JP Corp Goods Price MM	7:50	0.4%	-0.2%

Маргааш хүлээгдэж буй мэдээ	Цаг	Таам.	Өмнөх
US U Mich Sentiment Prelim	23:00	67.5	67.2
GE HICP Final YY	15:00	5.1%	5.1%
UK GDP Prelim YY	17:30	6.4%	6.8%
UK GDP Prelim QQ	17:30	1.1%	1.1%
UK Manufacturing Output MM	15:00	0.1%	1.1%

### Мэдэгдэл

Энэхүү мэдээлэл нь ХХБ-ны нэрийн өмнөөс тус банкны харилцагчдад мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгддэг бөгөөд аливаа нэг гадаад валют, санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах болон хөрөнгө оруулалтийг санал болгоогүй болно. Мөн энэхүү мэдээлэл нь аль нэгэн харилцагчийн хөрөнгө оруулалтанд, санхүүгийн байдал болон тусгайлсан эрэлт, хэрэгцээнд тулгуурлаагүй бөгөөд ХХБ нь энэхүү мэдээллийн үнэн зөв болон бодит байдлад ямарваа нэгэн баталгаа гаргахгүй ба мэдээллийг ашигласнаас үүдэн бий болох аливаа алдагдал, сөрөг үр дагаварт харууллага хүлээхгүй болохыг мэдэгдэж байна. Энэхүү мэдээлэл нь зохиогчын эрх бүхий мэдээллүүдийг агуулж буй тул зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, гуравдагч этгээдэд түгээхийг хатуу хориглоно. Хэрэв энэхүү мэдээллийг цаашид хүлээн авахаа зогсоохыг хүсвэл гарчиг хэсэгт "UNSUBSCRIBE" гэж бичин ут и-мэйлд харуу илгээнэ үү.

72,580 юань боллоо.

### Газрын тосны зах зээл

АНУ-ын нөөц буурснаас шалтгаалан өчигдөр өссөн газрын тосны үнэ өнөөдөр хүчтэй хөдөлгөөнгүй байна. Хөрөнгө оруулагчид АНУ болон Иран улсын хэлэлцээр амжилттай болох эсэхэд их анхаарал хандуулж, хүлээж байна. Brent газрын тосны үнэ 0.1 хувь буурч 91.45 ам.долларт арилжаалагдаж байна.

### Бондын зах зээл

АНУ-ын Хэрэглэгчдийн үнийн индекс 1982 оноос хойших хамгийн өндөр түвшинд очих төлөвтэй байгаа учир Азийн арилжаагаар АНУ-ын Засгийн бондын фьючерс буурлаа. Лхагва гарагт 10 жилийн хугацаатай өрийн бичгийн дуудлага худалдаагаар эрэлт сайн байсан учир Засгийн бонд өндрөөр хаагдсан. Гэвч уг өсөлт нь Пүрэв гарагт болох 30 жилийн хугацаатай бондын худалдаа болон 1 сарын Хэрэглэгчдийн үнийн индексийн тайлангийн өмнө үгүй боллоо. Goldman Засгийн бондын өгөөжийн талаарх өөрсдийн таамгаа өсгөж жилийн эцэст 2 жилийн хугацаатай өгөөжийг 1.9%, 10 жилийн хугацаатай өгөөжийг 2.25% болголоо.

### Хөрөнгийн зах зээл

Азийн хөрөнгийн зах зээл тогтвортой байгаа бол АНУ-ын фьючерсүүд уналттай байна. Арилжаачид өнөөдөр гарах инфляцийн мэдээг хүлээж байна. Тус мэдээ нь Холбооны Нөөцийн банк мөнгөний бодлогыг хэр зэрэг чангаруулах чухал нөлөөтэй юм. Өчигдөр S&P 500 хүчтэй өссөн бол Nasdaq100 хоёр орчим хувь өссөн байна. Uber болон Walt Disney-ийн ашиг өндөр гарснаар их өсөлт үзүүлээ.